



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 01 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар ХЭТ/119

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хүнсний үйлдвэрлэл, хангамжийг дээшлүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн хийх мэдээллийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000021500048

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал дэгдсэн онцгой нөхцөл байдлын үед хүн амын хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах, хүнсний нөөц, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх нэн чухал шаардлага тулгарч байна.

2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штабыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр долоо хоног тутам судлан гаргаж, нөөцийн урсгал хөдөлгөөнд дүн шинжилгээ, зохицуулалт хийн ажиллаж байна.

2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 16.5 мянган тонн малын мах, 112.7 мянган тонн гурил, 1.6 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 14.1 мянган тонн төрөл бүрийн будаа, 1.6 мянган тонн хуурай сүү, 830 мянган ширхэг өндөг, 3.8 мянган тонн ургамлын тос, 97.1 мянган тонн төмс, 41.3 мянган тонн хүнсний ногоо, 4.5 мянган тонн элсэн чихэр, 1.2 мянган тонн давсны нөөцтэй байна. Хүнсний нөөцийг улсын хэмжээнд хоногоор тооцож үзвэл, малын махны 52, гурил, гурилан бүтээгдэхүүний 183, төрөл бүрийн будааны 106, хуурай сүүний 33, ургамлын тосны 62, төмсийн 305, хүнсний ногооны 60, элсэн чихрийн 53 хоногийн нөөцтэй байна.

Импортын хамааралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хувьд томоохон импортлогчдоос авсан судалгаагаар 2021 оны 1-2 дугаар сард 6.2 мянган тонн цагаан будаа, 5.1 мянган тонн элсэн чихэр, 500 тонн ургамлын тос импортоор орж ирэх захиалгатай байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц, хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа шуурхай арга хэмжээний үр дүнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж улсын хэмжээнд харьцангуй тогтвортой байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоолгүйгээр нарийн цагийн хуваарийн дагуу зохицуулж байгаа бөгөөд хүн амын хүнсний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах чиглэлд онцгой анхаарч байна.

Улсын хэмжээнд 2020 онд 394.6 мянган га талбайд үр тариа, үүнээс 364.0 мянган га талбайд улаанбуудай, 18.6 мянган га талбайд төмс, 9.6 мянган га талбайд хүнсний ногоо, 61.1 мянган га талбайд тосны ургамал, 52.7 мянган га талбайд тэжээлийн ургамал, нийт 536.6 мянган га талбайд тариалалт хийсэн. КОВИД-19 халдварын цар тахлын үед ургамлын гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах зорилгоор улаанбуудайн тариалалтыг өнгөрсөн жилтэй харьцуулахад 10.6 хувиар, төмсийг 18.1 хувиар, хүнсний ногоог 26.5 хувиар тус тус илүү тариалсан.

Гэвч ургац хураалтын явцад бүх тариалангийн нутгийг хамран орсон 2-3 удаагийн хүйтэн бордоо, нойтон цас, цасан шуурганд нийт 70.8 мянган га талбайн ургац өртөж, 36.7 мянган га улаанбуудайн талбай ногоон тэжээлд шилжсэнээр хураан авахаар төлөвлөсөн ургацын хэмжээ буурахад хүрсэн.

2020 онд улсын хэмжээнд нийт 400.8 мянган тонн улаанбуудай, 238.7 мянган тонн төмс, 109.2 мянган тонн хүнсний ногоо, 160.0 мянган тонн тэжээлийн ургамал, 20.2 мянган

тонн тосны ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд нийт 242.8 мянган тонн хүнсний улаанбуудайг нийлүүлжээ.

Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, үндэсний үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2020-2021 онд нийт 150 мянган тонн хүнсний улаанбуудай, 40 мянган тонн улаанбуудайн үр импортлохоор төлөвлөж, хүнсний улаан буудай импортлоход шаардагдах 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөгжлийн банкны эх үүсвэрээс гаргахаар шийдвэрлэлээ. Ингэснээр гурил, гурилан бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой хадгалах, 2021 оны хаврын тариалалтыг чанартай зохион байгуулах нөхцөл, боломж бүрдэнэ.

Улсын хэмжээнд 2020 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр 67.1 сая толгой мал тоологдсон бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 3.9 сая тоо толгой буюу 5.5 хувиар буурсан байна. Энэ нь 2020 онд ихэнх нутагт зуншлага оройтож, зудын эрсдэл нэмэгдсэн, бэлчээрийн даац хэтэрч, өвс, тэжээлийн эрэлт, хэрэгцээ ихэссэн зэргээс үүдэн малыг зах зээлд нийлүүлж, мах бэлтгэлийг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд нийслэлийн хүн амын 2021 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 20 мянган тонн мах бэлтгэж нөөцлөх ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр дотоодын зах зээлд үнийн хөөрөгдөл үүсэхгүй байх, махны хангамжийг тогтворжуулах нөхцөл бүрдэнэ.

КОВИД-19 халдварын цар тахлын үеийн нөхцөл байдлыг харгалзан нөөцийн махыг 2020 оны 11 дүгээр сарын 14-22-ны өдрүүдэд худалдаалсан бөгөөд энэ хугацаанд нийт 500 тонн мах нийлүүлжээ.

КОВИД-19 халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжих бодлого баримталж байна.

Энэ хүрээнд бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн, зун зуншлага муу байсан, өвөлжилт хүндэрч болзошгүй Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай аймагт зудын эрсдэлийн үнэлгээ хийж, эдгээр аймгаас 5.2 сая толгой малыг бэлтгэж, нийт 40 мянган тонн дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлохоор Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн. Үүний дагуу холбогдох зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, мал, мах бэлтгэлийн ажил орон нутагт явагдаж байна.

Мөн Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хурлаар 15 мянган тонн адууны мах экспортлох тоо хэмжээг нэмэлтээр тогтоож, Хүнсний тухай хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мах, махан бүтээгдэхүүн экспортлох арга хэмжээг зохион байгуулахдаа төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд махны дотоодын хангамжийг тасалдуулахгүй, нийлүүлэлтийн зохиомол хомсдол, үнийн хэт хөөрөгдөл үүсгэхгүй байхад анхаарч байна.

Манай улсын байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж, цагаан будаа, элсэн чихэр тариалах боломж хязгаарлагдмал байдаг тул эдгээр гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамж импортоос шууд хамааралтай байдаг. Иймд төрөл бүрийн будаа, элсэн чихэр, ургамлын тосны импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс мөн оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлж, хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулсан.

Дэлхийн олон улсад КОВИД-19 халдварын цар тахлын хөёр дахь давллагаа үргэлжилж, хамрах хүрээ нэмэгдэж байгаа талаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдэгдэж байна. Иймд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой

байдлыг урт хугацаанд хадгалах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж, дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тосыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд тус тус чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас импортлогч аж ахуйн нэгжүүдтэй дотоодын зах зээлд нийлүүлэлтийг тогтворжуулах, үнийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд төрөл бүрийн будаа, хүнсний улаанбуудай, ургамлын тосны нөөц, хангамжийг цаашид тогтвортой хадгалах нөхцөл бүрдэх бөгөөд импортын үйл ажиллагааг шуурхай зохицуулж, гаалийн хялбаршуулсан бүрдүүлэлт хийн ажиллаж байна.

Улсын хэмжээнд хүнсний хангамж тогтвортой байгаа боловч эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг өрхийн түвшинд баталгаажуулах, хүнсээр таслахгүй байх нь нэн чухал юм. Энэ хүрээнд Хөдөлмөр, нийгмийн, хамгааллын яамнаас КОВИД-19 халдварын цар тахлын нөхцөлд хүн амын нийгмийн халамж, хамгааллын тусламж шаардлагатай 11 кластер бүлгийг тодорхойлж, эдгээр бүлэгт хүнсний тусламж үзүүлэхэд олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудыг татан оролцуулж, дэмжлэг авах байдлаар хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран улсын хэмжээнд 10 мянга гаруй айл өрхөд хүнсний тусламж үзүүлээд байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц, хангамж, нийлүүлэлт тогтвортой байгаа боловч хөл хорионд байгаа зарим айл өрхүүд хоол хүнсийг хэрэгцээнээсээ илүү хэмжээгээр худалдан авах, зохисгүй хадгалах, хаяж үрэгдүүлэх хандлага гарч байна. Иймд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хадгалах хүрээнд хүн амын хоол хүнсний зохистой худалдан авалт, хэрэглээний талаарх мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "хүнсний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, экспортыг дэмжих" зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хүнсний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих, салбарт чиглэсэн төсвийн урамшууллыг чанар, үр дүнтэй уялдуулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн Атрын 4 дүгээр аяныг зарлаж, газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, усалгаатай тариаланг хөгжүүлэх, хүнсний ногооны үйлдвэрлэлийг дотооддоо бүрэн хангах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын төв, ложистик, агуулахын сүлжээ, хүлэмжийн цогцолбор байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэхээр зорьж байна.

Мөн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монголын ард түмнээс Хятадын ард түмэнд бэлэглэсэн 30 мянган хонийг зүүн аймгуудаас бэлтгэж, халдвар хамгааллын дэглэм дор хүргүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан нь хөрш орны зах зээл, хэрэглэгчдэд монгол малын махны чанар, мах, махан бүтээгдэхүүний экспортыг сурталчилсан чухал алхам болсон гэж дүгнэж байна.

Үүний зэрэгцээ БНХАУ-ын Гадаад харилцааны сайд Ван И-ийн 2020 оны 9 дүгээр сард манай улсад хийсэн ажлын айлчлалын үеэр "Монгол Улсаас БНХАУ-д хөх тарианы гурил экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай протокол"-ыг тохирсон. Энэ ажлын үр дүнд манай улсаас БНХАУ-д хөх тарианы гурил экспортлох нөхцөл, боломж бүрдлээ.

КОВИД-19 халдварын цар тахлын үед мэргэжлийн хяналтын байгууллагаас хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд чанар, аюулгүй байдлын хяналт, зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд 2020 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас эрсдэлд суурилсан төлөвлөгөөт хяналт шалгалтыг гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, савласан цэвэр ус, рашаан, нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 345 үйлдвэр, цехэд хийж гүйцэтгэжээ. Шалгалтад хамрагдсан үйлдвэрүүдийн 52 хувь нь үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавигдах шаардлагыг, 42.6 хувь нь түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг, 47.3 хувь нь технологийн үйл ажиллагааг, 28.3 хувь нь бүтээгдэхүүний хаяг шошго, хадгалалт, тээвэрлэлт, баталгаажуулалтыг, 58 хувь нь дотоод хяналт, бүртгэлийг, 33.6 хувь нь ажиллагсдад тавигдах шаардлагыг тус тус хангаагүй зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

Мөн 2020 оны эхний 11 сарын байдлаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид дотоодын үйлдвэрийн болон импортын хүнсний бүтээгдэхүүний нийт 16.8 мянган дээжийг хими, нян, хор судлал, хүнд металлын үлдэгдэл, цацрагийн бохирдол тодорхойлох шинжилгээнд хамруулснаас химийн үзүүлэлтээр 768 дээжид, нян судлалын үзүүлэлтээр 308 дээжид эерэг буюу 6.46 хувь нь стандартын шаардлага хангаагүй гэсэн дүн гарсан байна. Улсын хэмжээнд 2020 оны эхний 11 сарын байдлаар 137 хүнсний үйлдвэрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллажээ.

Цаашид Монгол Улсын Засгийн газар хүнсний салбарт богино, дунд хугацаанд дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

-Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, импортын хамаарлыг бууруулах;

-Мах, махан бүтээгдэхүүн болон согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг шинээр баталж, хэрэгжилтийг хангуулах;

-“Баяжуулсан хүнс” бодлогын баримт бичгийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

-“Эрүүл хүн-Эрүүл монгол хүн”, “Сав, баглаа боодол”, “Хүнсний ногоо”, “Жимс, жимсгэнэ”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” зэрэг үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

-Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний улирлын хамаарлыг бууруулах, хүнсний импортыг орлох, экспортын баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

-Монгол Улсын худалдааны бодлого, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох хуулийн төсөл боловсруулах.